



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерэнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/171-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Сүхбаатар сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитын гүйцэтгэсэн: Пийк Ом Аудит ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
 - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БҮХТ	Боловсролын үнэлгээний хөгжлийн төв



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.25 № ООА-2022/171-НА-СТА-2023
танай _____-ны № _____-т

**САЙХАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.ИЧИНХОРЛОО ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 99.0 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 2,646.2 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6,743.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 514.5 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 11,943.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсөв 1.0 хувиар хэмнэгдсэн байна.

018020102

Аудитын гол асуудал

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 63.8 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 21.1 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байна.

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/343 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 53,197.5 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	226,006,990.5	256,051,481.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		21,847,989.4
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		21,847,989.4
3121	Төгрөг		21,847,989.4
31211	Төрийн сангийн харилцах		21,847,989.4
33	АВЛАГА	698,945.0	698,945.0
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	698,945.0	698,945.0
35	БАРАА МАТЕРИАЛ	225,308,045.5	233,504,547.3
351	Түүхий эд материал	280,000.0	622,600.0
3513	Эм боох материал	280,000.0	622,600.0
354	Хангамжийн материал	225,028,045.5	232,881,947.3
3541	Бичиг хэргийн материал	11,952,378.2	13,749,800.2
3542	Аж ахуйн материал	178,491,184.4	178,533,184.4
3543	Сэлбэг хэрэгсэл		1,292,500.0
3545	Барилгын засварын материал	8,109,357.0	7,887,357.0
3547	Бусад хангамжийн материал	26,475,125.9	31,419,105.7
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,774,839,357.3	2,736,767,036.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,774,839,357.3	2,736,767,036.1
392	Биет хөрөнгө	2,734,032,357.3	2,687,903,036.0
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,821,815,400.0	2,821,815,400.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(308,183,046.4)	(411,403,349.4)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	59,802,400.0	59,802,400.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,946,465.1)	(34,470,455.2)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	243,950,863.9	332,775,463.9
39206	Хуримтлагдсан элэгдэл	(147,005,315.9)	(174,858,298.2)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	129,062,911.7	140,957,211.7
39208	Хуримтлагдсан элэгдэл	(68,614,361.2)	(79,516,942.2)
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,321,737.0	24,321,737.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(23,102,459.8)	(23,450,824.8)
39217	Ном	31,930,693.2	31,930,693.2
393	Биет бус хөрөнгө	40,807,000.0	48,864,000.1
39301	Програм хангамж	9,482,430.0	18,482,430.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,552,430.0)	(2,495,429.9)
39303	Бусад биет бус хөрөнгө	32,877,000.0	32,877,000.0
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,000,846,347.8	2,992,818,517.8
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	263,988,402.3	331,459,164.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	263,988,402.3	331,459,164.6
413	Өглөг	263,988,402.3	331,459,164.6
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	263,988,402.3	331,287,461.6
4136	Бусад өглөг		171,703.0
41361	Байгууллагад төлөх өглөг		171,703.0

V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,736,857,945.5	2,661,359,353.2
51	Засгийн газрын хувь оролцоо	2,736,857,945.5	2,661,359,353.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	519,308,098.8	519,308,098.8
512	Хуримтлагдсан үр дүн	(918,670,785.3)	(994,169,377.6)
5121	Өмнөх үеийн үр дүн	(918,670,785.3)	(3,918,818,188.1)
5122	Тайлант үеийн үр дүн		2,924,648,810.5
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,136,220,632.0	3,136,220,632.0
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,000,846,347.8	2,992,818,517.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,531,689,955.0	5,277,436,885.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,213,220.3	3,044,499,622.8
120	Нийтлэг татварын бус орлого	44,213,220.3	3,031,624,767.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		5,739,900.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		5,739,900.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	21,679,903.1	2,784,069,357.3
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	22,533,317.2	241,815,510.4
121	Хөрөнгийн орлого		10,861,780.0
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого		10,861,780.0
122	Тусламжийн орлого		2,013,075.0
122001	Хандив тусламж /дотоод/		2,013,075.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,487,476,734.7	2,232,937,263.2
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,210,560,700.0	1,703,868,400.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,703,868,400.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,210,560,700.0	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,038,234.7	1,891,543.2
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,026,644.7	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,627,980.0	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,383,610.0	1,891,543.2
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	242,877,800.0	527,177,320.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		527,177,320.0
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	242,877,800.0	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,692,068,951.0	2,352,788,075.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,692,068,951.0	2,352,788,075.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,653,853,401.0	2,240,124,175.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,003,900,300.0	1,262,346,689.6
210101	Үндсэн цалин	656,477,540.6	877,528,329.0
210102	Нэмэгдэл	284,974,694.4	311,975,332.6
210104	Урамшуулал	62,448,065.0	36,478,567.0
210105	Гэрээт ажлын хөлс		36,364,461.0

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,480,400.0	159,514,821.0
210201	Тэтгэврийн даатгал	87,053,000.0	109,436,135.6
210202	Тэтгэмжийн даатгал	10,042,900.0	12,712,465.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,034,300.0	10,065,812.1
210204	Ажилгүйдлийн даатгал	2,008,600.0	2,135,879.3
210205	Эрүүл мэндийн даатгал	25,341,600.0	25,164,529.0
2103	Байр ашиглалттай холбоотой тэгтмол зардал	306,972,870.3	534,334,059.2
210301	Гэрэл, цахилгаан	9,157,775.0	12,144,614.0
210302	Түлш, халаалт	290,309,366.3	510,596,589.2
210303	Цэвэр, бохир ус	7,505,729.0	11,592,856.0
2104	Хангамж, бараа материалын зардал	46,229,551.0	64,622,589.3
210401	Бичиг хэрэг	22,671,918.0	33,039,213.1
210402	Тээвэр, шатахуун	1,300,000.0	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	920,000.0	
210404	Ном, хэвлэл	9,177,700.0	310,300.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	688,000.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,471,933.0	26,920,866.2
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		4,352,210.0
2105	Нормативт зардал	3,671,034.7	30,336,150.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	962,600.0	526,350.0
210502	Хоол, хүнс	1,598,434.7	29,809,800.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,110,000.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,546,250.0	
210604	Урсгал засвар	3,546,250.0	
2107	Томилолт, зочны зардал	545,300.0	
210702	Дотоод албан томилолт	545,300.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,219,950.0	9,857,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,059,950.0	5,725,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,160,000.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,132,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	149,287,745.0	179,112,866.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		27,262,645.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,129,000.0	4,059,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	144,158,745.0	147,791,221.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,215,550.0	112,663,900.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,215,550.0	112,663,900.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,415,550.0	78,085,600.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.0	34,578,300.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(160,378,996.0)	2,924,648,810.5
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	21,679,903.1	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	21,679,903.1	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(21,679,903.1)	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(182,058,899.1)	2,924,648,810.5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГ ЫН ДҮН (1)	1,487,476,734.7	2,251,552,018.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		18,614,755.0
120	Нийтлэг татварын бус орлого		5,739,900.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		5,739,900.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		5,739,900.0
121	Хөрөнгийн орлого		10,861,780.0
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого		10,861,780.0
122	Тусламжийн орлого		2,013,075.0
122001	Хандив тусламж /дотоод/		2,013,075.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,487,476,734.7	2,232,937,263.2
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,210,560,700.0	1,703,868,400.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,703,868,400.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,210,560,700.0	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,038,234.7	1,891,543.2
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,026,644.7	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,627,980.0	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,383,610.0	1,891,543.2
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	242,877,800.0	527,177,320.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	242,877,800.0	527,177,320.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,468,302,034.1	2,129,215,128.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,468,302,034.1	2,129,215,128.8
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,430,992,934.1	1,988,738,828.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,003,900,299.4	1,272,379,905.5
210101	Үндсэн цалин	657,440,700.0	887,561,544.9
210102	Нэмэгдэл	284,011,534.4	311,975,332.6
210104	Урамшуулал	62,448,065.0	36,478,567.0
210105	Гэрээт ажлын хөлс		36,364,461.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,480,400.0	149,481,605.2
210201	Тэтгэврийн даатгал	92,308,800.0	106,215,717.2
210202	Тэтгэмжийн даатгал	10,042,900.0	10,987,797.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,034,300.0	8,780,418.2
210204	Ажилгүйдлийн даатгал	2,008,600.0	2,135,879.3
210205	Эрүүл мэндийн даатгал	20,085,800.0	21,361,793.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	242,432,200.0	468,975,000.0
210301	Гэрэл, цахилгаан	9,157,775.0	12,144,614.0
210302	Түлш, халаалт	225,768,696.0	445,237,530.0
210303	Цэвэр, бохир ус	7,505,729.0	11,592,856.0
2104	Хангамж, бараа материалын зардал	23,966,420.0	1,891,543.2
210401	Бичиг хэрэг	5,227,648.0	

210402	Тээвэр, шатахуун	1,300,000.0	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	920,000.0	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,044,000.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, агаарын эд зүйлс	15,474,772.0	1,891,543.2
2105	Нормативт зардал	3,393,134.7	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	352,600.0	
210502	Хоол, хүнс	1,598,434.7	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,442,100.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,810,200.0	20,445,600.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,327,000.0	
210602	Тавилга	411,900.0	
210604	Урсгал засвар	6,071,300.0	20,445,600.0
2107	Томилолт, зочны зардал	545,300.0	
210702	Дотоод албан томилолт	545,300.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,694,930.0	9,857,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,534,930.0	5,725,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,160,000.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,132,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,770,050.0	65,708,175.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		45,759,075.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,770,050.0	19,949,100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,309,100.0	140,476,300.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,309,100.0	140,476,300.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,509,100.0	105,898,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.0	34,578,300.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	19,174,700.6	122,336,889.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,515,000.0	100,488,900.0
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	19,515,000.0	100,488,900.0
	Дотоод эх үүсвэрээр	19,515,000.0	100,488,900.0
223001	Бусад хөрөнгө	19,515,000.0	100,488,900.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(19,515,000.0)	(100,488,900.0)
VII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(340,299.4)	21,847,989.4
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		21,847,989.4

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	519,308,098.8	3,136,220,632.0	(918,670,785.3)	2,736,857,945.5
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(3,000,147,402.8)	(3,000,147,402.8)
17	Тайлант үеийн үр дүн			2,924,648,810.5	2,924,648,810.5
19	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	519,308,098.8	3,136,220,632.0	(994,169,377.6)	2,661,359,353.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,249,660,475.00	2,227,812,485.65	21,847,989.35	99.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,249,660,475.00	2,227,812,485.65	21,847,989.35	99.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,097,240,775.00	2,087,336,185.65	9,904,589.35	99.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,275,026,161.00	1,272,379,905.50	2,646,255.50	99.79
210101	Үндсэн цалин	910,255,400.00	887,561,544.86	22,693,855.14	97.51
210102	Нэмэгдэл	291,749,500.00	311,975,332.64	-20,225,832.64	106.93
210104	Урамшуулал	36,656,800.00	36,478,567.00	178,233.00	99.51
210105	Гэрээт ажлын хөлс	36,364,461.00	36,364,461.00	-	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,225,159.00	149,481,605.15	6,743,553.85	95.68
210201	Тэтгэврийн даатгал	106,281,117.93	106,215,717.21	65,400.72	99.94
210202	Тэтгэмжийн даатгал	12,503,737.19	10,987,797.43	1,515,939.76	87.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,002,929.76	8,780,418.22	1,222,511.54	87.78
210204	Ажилгүйдлийн даатгал	2,494,379.46	2,135,879.30	358,500.16	85.63
210205	Эрүүл мэндийн даатгал	24,942,994.66	21,361,792.99	3,581,201.67	85.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	468,975,000.00	468,975,000.00	-	100
210301	Гэрэл, цахилгаан	12,824,000.00	12,144,614.00	679,386.00	94.7
210302	Түлш, халаалт	442,695,700.00	445,237,530.00	-2,541,830.00	100.57
210303	Цэвэр, бохир ус	13,455,300.00	11,592,856.00	1,862,444.00	86.16
2106	Эд хогшил урсгал засвар	20,445,600.00	20,445,600.00	-	100
210604	Урсгал засвар	20,445,600.00	20,445,600.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,299,400.00	12,784,620.00	514,780.00	96.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		8,652,620.00	-8,652,620.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,299,400.00	4,132,000.00	9,167,400.00	31.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	163,269,455.00	166,197,075.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	143,320,355.00	143,320,355.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,949,100.00	19,949,100.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	152,419,700.00	140,476,300.00	11,943,400.00	92.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	152,419,700.00	140,476,300.00	11,943,400.00	92.16

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	117,841,400.00	105,898,000.00	11,943,400.00	89.86
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,578,300.00	34,578,300.00	-	100
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,249,660,475.00	2,249,660,475.00	-	100
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,703,868,400.00	1,703,868,400.00	-	100
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,703,868,400.00	1,703,868,400.00	-	100
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	527,177,320.00	527,177,320.00	-	100
320001	Орон нутгийн төсвөөс	527,177,320.00	527,177,320.00	-	100
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	18,614,755.00	18,614,755.00	-	100
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,739,900.00	5,739,900.00	-	100
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	2,013,075.00	2,013,075.00	-	100
122	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	2,013,075.00	2,013,075.00	-	100
121	туслах үйл ажиллагаа	10,861,780.00	10,861,780.00	-	100
5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		21,847,989.35	21,847,989.35	
	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
	АЖИЛЛАГСДЫН ТОО	85	85	-	100
	Удирдах	1	1	-	100
	Гүйцэтгэх	69	69	-	100
	Үйлчлэх	15	15	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,891,543.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,891,543.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,891,543.2
2104	Хангамж, бараа материалын зардал	1,891,543.2
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,891,543.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,891,543.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,891,543.2

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь “Хүүхдийн хөгжлийг тасралтгүй дэмжиж, хичээл сургалтын үйл ажиллагааг хосолсон хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулж хоцрогдлыг нөхөх, арилгахад бүх талын оролцоог дэмжин ажиллах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагч бүрийг боловсролд тэгш хамруулах, сургууль завсардахаас сэргийлэх, “Ногоон гэрэл” хөтөлбөрийг үр дүнтэй хүртээмжтэй хэрэгжүүлэх,
- Хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж цахим хичээлийн болон даалгаврын сан бүрдүүлэн ашиглах,
- Багш, удирдах ажилтан бүр сургалтын арга хэлбэрийг оновчтой сонгон, заах арга зүй, мэдлэг ур чадвараа хөгжүүлж, ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх,
- Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зорилтот арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх,
- Мэргэжил, арга зүйн байгууллага болон мэргэжлийн бүлгээр хамтран ажиллаж, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэн сургалт үйл ажиллагааны чанарыг сайжруулах,
- Ажлын байран дээрх эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг бэхжүүлэх,
- Багш, ажилтны хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,

- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг гөлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагч болох БШУЯ-ны зүгээс дотоод аудит, хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн

ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,027.8 мянган төгрөгөөр буюу 26.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		21,848.0	21,848.0
Авлага	698.9	698.9	-
Бараа материал	225,308.0	233,504.5	8,196.5
Үндсэн хөрөнгө	2,774,839.4	2,736,767.0	(38,072.3)
Нийт хөрөнгө	3,000,846.3	2,992,818.5	(8,027.8)
Өр төлбөр	263,988.4	331,459.2	67,470.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,736,857.9	2,661,359.4	(75,498.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,000,846.3	2,992,818.5	(8,027.8)

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 21,848.0 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 233,504.5 мянган төгрөг болж 8,196.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 164,733.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, БШУЯ-наас 9,755.4 мянган төгрөгийн сурах бичиг, 6,752.1 мянган төгрөгийн багаж хэрэгслийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан болон үйл ажиллагаанд 173,044.3 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 3,462,962.3 мянган төгрөг болж 109,718.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 103,018.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан болон БШУЯ-наас 6,700.0 мянган төгрөгийн гадна камерыг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 331,459.2 мянган төгрөг болж 67,470.8 мянган төгрөгөөр өссөн нь санхүүжилт хүрэлцээгүйгээс он дамжсан халаалтын өрийг барагдуулж дуусаагүй, тайлант онд шинээр 65,359.0 мянган төгрөгийн халаалтын өр шинээр нэмэгдсэн, нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас 1,940.0 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг, 171.7 мянган төгрөгийн ХХОАТ өглөг үүссэн зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,661,359.4 мянган төгрөг болж 75,498.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,792,516.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 527,177.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,196,693.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас тэтгэвэр тэтгэмжийн зардлыг 100,618.4 мянган төгрөгөөр бууруулж, нийт төсвийг 2,096,075.4 мянган төгрөгөөр баталсан байна.

2022 оны 05 дугаар сард орон нутгийн төсвөөс төрийн үйлчилгээний ажилчдын цалин улсын төсвөөс санхүүжигдэхээр болж 11 дүгээр сард хийсэн төсвийн зохицуулалтаар байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах бараа үйлчилгээний бусад зардал 77,891.9 мянган төгрөгийг, үдийн цай хөтөлбөр 22,500.0 мянган төгрөгийг, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 34,578.3 мянган төгрөг нийт 134,970.2 мянган төгрөгөөр төсвийг нэмэгдүүлж улсын төсвөөс 1,703,868.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 527,177.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 18,614.8 мянган төгрөг нийт 2,249,660.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,703,868.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 527,177.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 18,614.8 мянган

төгрөг нийт 2,249,660.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,227,812.5 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 2,646.2 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6,743.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 514.5 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 11,943.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	5,319.7	5,319.7	-	100.0
		2	80312- Сургалт семинар	2,659.9	2,327.5	332.4	87.5
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	6,117.7	6,117.7	-	100.0
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	117,841.4	105,898.0	11,943.4	89.9
		5	81816- Хүүхдэд эзлтэй сургалтын орчин	73,821.5	73,821.5	-	100.0
		6	81823- Боловсролын багшийн сургалт	11,969.4	11,969.4	-	100.0
		7	81834- Боловсролын стандарт сургалт	1,335,476.8	1,329,411.1	6,065.7	99.5
		8	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	150,662.0	147,170.6	3,491.4	97.7
		9	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	10,861.6	10,861.6	0.0	100.0
		10	81848-Сурах бичгийн түрээс	5,739.9	5,725.0	14.9	99.7
		11	83603- Дээд шатны төсвөөс	2,013.1	2,013.1		100.0
		12	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	489,420.6	489,420.6	-	100.0
		13	80112- Нийтлэг үйлчилгээ	37,756.7	37,756.7	-	100.0
		Нийт		2,249,660.5	2,227,812.5	21,848.0	99.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд автобус түрээсийн орлого 1,891.5 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зохих дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр, ашигтай зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк Ом Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,692,068.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,920.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх НДШ, үдийн цай хөтөлбөр, сургалт семинарын зардлаас нийт 21,848.0 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 20 төрлийн 170 мэдээллээс 65 мэдээллийг хугацаа хоцроож, 14 мэдээллийг огт мэдээлээгүй бөгөөд мэдээллийн хэрэгжилт 46.4 хувьтай байна.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн боловч бүрэн хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд мэдээлбэл зохих 20 төрлийн 170 мэдээлэл байршуулахаас 65 мэдээллийг хугацаа хоцроож, 14 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

- Төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 17 удаа хугацаа хоцроож, 10 удаа огт мэдээлээгүй,
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 22 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Бусад мэдээллийг 26 удаа хугацаа хоцроож, 4 удаа огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд алдаа зөрчил давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан,

хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом Аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 02-ны 201 дүгээр албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан 1,268.2 мянган төгрөгийн ХХОАТ-ын өр төлбөр, хамтын сангийн тооцоотой холбоотой 190.8 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн боловч аудитаар өр төлбөр үүсгэсэн бөгөөд төлбөрийн цахим баримттай холбоотой 39,990.7 мянган төгрөгийн зөрчил, хөрөнгийн тооллоготой холбоотой зөрчлийг арилгах зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 33.3 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган
төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	510.2	1	510.2	100.0
Албан шаардлага	2	2,244.0	1	1,122.0	50.0
Зөвлөмж	3	127,907.7	1	42,593.3	33.3
Нийт дүн	6	130,611.9	2	44,225.5	33.3

Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар

өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Өмнөх аудитаар өр төлбөр, авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд алдаа зөрчил давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн нягтлан бодогч Н.Баяртогтоход **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлууд нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан, хяналт тавьж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлтэй байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
3. Тус сургуулийн нягтлан бодогч Н.Баяртогтохын ажлыг улирал бүр дүгнэж, ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 30.0-45.0 хувиар тооцож олгосон боловч Боловсролын Ерөнхий газрын даргын 2022 оны 1/643 дугаар тушаалаар салбарын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр 1,595.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид улирлын ажлын мөнгөн урамшуулалтай давхардуулан, хууль, эрх зүйн үндэслэлд нийцээгүй урамшуулал олгохгүй байх нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах **34,825.0** мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн тайланд цалингийн санг 1,033.2 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн,
2. Бараа материалын тайлангийн орлого, журналын орлогоос 32,648.7 мянган төгрөгөөр зөрүүтэй,
3. Шатахууныг бараа материалын тайланд орлогоор бүртгэлгүй, 1,143.1 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардлаар бүртгэсэн

Аудитаар нийт **21,846.0** мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлснээс 5,270.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 9,647.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 6,928.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Багш, ажилчдын цалингаас суутгасан хамтын сан, хоолны төлбөрийн тооцооллыг хянаагүйгээс цалингийн зардлаас **2,670.0** мянган төгрөгийг илүү шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаа куулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү шилжүүлсэн 2,670.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Нэр бүхий багш, ажилтнуудад олгосон цалингийн урьдчилгаа 2,600.0 мянган төгрөгийг дутуу суутгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу суутгасан **2,600.0** мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох,

5.2 Албан шаардлага

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 7,536.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

2. Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас Болжимцайдам ХХК-д 1,940.0 мянган төгрөгийн, Шунхлай петролиум ХХК-д 171.7 мянган төгрөгийн зэрэг нийт 2,111.7 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, төлбөр тооцоог урьдчилан хянасны үндсэн дээр өр төлбөр, авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх

3. Эд хариуцагч солигдоход эд хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулж ажил хүлээлцээгүй, шинээр авсан үндсэн хөрөнгийг тооллогын бүртгэлд тусгаагүй, анхны өртгөөр тоолж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.2 дэх “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эд хөрөнгийн тооллогыг чанартай, үнэн зөв хийж байх, хууль тогтоомжийг мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэх,

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин хөлстэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант оны төсөвт тусгаагүй байхад багш, ажилтнуудад 6,928.3 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг 3 сарын дундаж цалингаас тооцож олгосон

3.Худалдан авалтыг НӨАТ-ын баримтаар баталгаажуулаагүй	1	7,536.0			1	7,536.0						
4.Өр төлбөр үүсгэсэн	1	2,111.7			1	2,111.7						
5.Төсөвт тусгагдаагүй зардал гаргаж илүү цагийн хөлсийг нэмэгдүүлэн олгосон	1	6,928.3					1	6,928.3				
6.Эд хариуцагч ажил хүлээлцэхэд тооллого хийгээгүй	1				1							
Нягтлан бодогчид хариуцлага тооцуулах	1									1		
Дүн	7	21,846.0	2	5,270.0	3	9,647.7	1	6,928.3	1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлэл хоцроосон	65	-			65	-		
Огт мэдээлээгүй	14				14			
Дүн	79				79			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	79				79			